



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 5/31

Улаанбаатар хот

Ажилтнуудад орон сууц худалдан авахад
санхүүгийн дэмжлэг олгох, гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, Компанийн захиргаа, ҮЭХ-ны хооронд байгуулсан 2021-2022 оны "Хамтын гэрээ"-ний 5.7 дахь заалт, Ажилтнуудад орон сууцны санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын 2.1, 2.2, 2.3, 2.4 дэх заалтууд, Нэмэлт ажил, үйлчилгээ зохицуулах журамын 5.4, захирлын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилтнуудад орон сууцны санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын нөхцөл шаардлагыг хангаж орон сууц худалдан авахад нь санхүүгийн дэмжлэг болгон тус бүр 25,000,000 (хорин таван сая) төгрөг, орон сууцны нөхцөл сайжруулах дэмжлэг болгон тус бүр 15,000,000 (арван таван сая) төгрөгийг олгох ажилтнуудыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Хавсралтад заагдсан ажилтнуудад олгох нийт 65,000,000 (жаран таван сая) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү эдийн засгийн албаны дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Т.Бямбажав)-т зөвшөөрсүгэй.
3. Орон сууц худалдан авахад санхүүгийн дэмжлэг авч буй ажилтнуудтай орон сууцны санхүүгийн дэмжлэг олгосон тухай гэрээ байгуулахыг Захиргаа удирдлагын албаны ахлах мэргэжилтэн (С.Намчиндорж)-д даалгасугай.
4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын алба (Б.Биндэръяа)-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.Балжинням





Гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 8/31 дугаар тушаалын хавсралт

Орон сууц худалдан авах, нөхцөл сайжруулахад санхүүгийн дэмжлэг авч буй ажилтнууд

№	Овог нэр	Албан тушаал	Санхүүгийн дэмжлэг ₮
1	Б.Ганбат	Төв диспетчерийн албаны дарга	15,000,000
2	Д.Бат-Эрдэнэ	Төв диспетчерийн албаны диспетчер инженер	25,000,000
3	Ц.Сэргэлэн	Горим төлөвлөлт тооцооны албаны ахлах инженер	25,000,000